



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/80

Хэрлэн сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Баян-Адрага сумын уугуул, Олимпийн мөнгөн медальт, Самбо бөхийн дэлхийн Хошой аварга, Монгол улсын өсөх идэр начин, нэрт жүдоч, Монгол Улсын Ардын багш, Гавьяат тамирчин, МУБИС-ийн хүндэт доктор, профессор, Монголын Үндэсний Олимпийн Хорооны дэд Ерөнхийлөгч Цэндийн Дамдин нь 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр таалал төгссөнд гэр бүлд нь хүсэлтийн дагуу буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Буцалтгүй тусламжинд шаардагдах 588500 /таван зуун наян найман мянга, таван зуу/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА